



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555
И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭДҮҮДЭД**

2024.11.24 № 01/2590
танай _____-ны № _____-т

Тодруулга хүргүүлэх тухай

Тус компаниас зарласан ЭТТХК/20240103136 дугаартай "Катерингийн үйлчилгээ (Уурхай, НБУ, ТНАЛТ)" үзүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт Монополын эсрэг газарт тендерт оролцохыг сонирхогч этгээдээс гомдол гарсны дагуу тус гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 01/1942 дугаартай "тендерийн баримт бичиг хянасан тухай" албан бичгийг ирүүлсэн.

Тус "тендерийн баримт бичиг хянасан тухай" албан бичигт "...Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж, 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/1770 дугаартай албан бичгээр тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулахыг захиалагчид даалгаж шийдвэрлэсэн. Иймд тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 9.1.1-д холбогдох гомдлыг Монополын эсрэг газраас хянаж шийдвэрлэсэн байх тул дахин шийдвэрлэхгүй болохыг үүгээр мэдэгдэж байна." гэсэн байна.

Монополын эсрэг газраас ирүүлсэн 01/1770 дугаартай "тендерийн баримт бичиг хянасан тухай" албан бичгийг тендерийн баримт бичигт шаардлагатай өөрчлөлтийг оруулан 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/2305 дугаартай албан бичгээр тендерт оролцохыг сонирхогч этгээдүүдэд тодруулга хүргүүлсэн.

Иймд Монополын эсрэг газраас ирүүлсэн 01/1942 дугаартай "тендерийн баримт бичиг хянасан тухай" албан бичгийн дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаа, тендерийн нээлт хийх хугацаанд орсон өөрчлөлтийг хүргүүлж байна. Үүнд:

ТШЗ-ны холбогдох заалт	В. ТЕНДЕР БЭЛТГЭХ
	Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ
ТШЗ 26.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Цаг: 09 цаг 00 минут Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй.
ТШЗ 26.2.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Цаг: 09 цаг 30 минут Тендер нээх газрын хаяг: "Эрдэнэс Таван толгой" ХК, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын-8 Финанс төв, 5-р давхар, 502 тоот, Улаанбаатар хот-15160, Монгол Улс

Дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ

1124044669